

АХЛАХ БҮЛЭГ БАГШИЙН АШИГЛАХ ДААЛГАВАР

Ахлах бүлгийн багш нь даалгавар гүйцэтгүүлэхийн өмнө үлгэр уншиж өгнө.

ШАНАГАН ХОРХОЙ ЭЭЖИЙГЭЭ ЭРСЭН НЬ

Хавар болж нуурын ус гэслээ. Эх мэлхий нуурын замагт жижиг жижиг хар өндөгнүүд төрүүлж гэнэ.

Өндөгнүүд том том толгойтой, нарийхан сүүлтэй шанаган хорхой болов.

Шанаган хорхойнууд:

Бидний ээж хаана байна аа? гэлцэн ээжийгээ хайхаар явлаа.

Гэнэт нууранд дэгдээхийгээ дагуулсан нугас ирэв. Шанаган хорхойнууд нугаснаас:

Та манай ээжийг таних уу? гэж асуув.

Нугас: Та нарын ээж чинь бүлтгэр нүдтэй, том амтай шүү дээ” гэхэд тэд бүлтгэр нүдтэй, том амтай ээжийгээ эрж, цааш явжээ.

Тэд өмнөөс нь ирж яваа загасыг харвал том амтай, бүлтгэр нүдтэй байв. Тэгэхээр нь: “Ээж ээ, ээж ээ” гэсээр загасыг тосон очив.

Тэгтэл өнөөх загас: Би та нарын ээж биш ээ.

Танай ээж дөрвөн хөлтэй шүү дээ” гэж хэлэв.

Тэд цааш хөвж явтал яст мэлхийтэй таарч, дөрвөн хөлийг нь хараад:

“Ээж ээ, ээж ээ” гэж дуудав.

Яст мэлхий: “та нарын ээж том гэдэстэй шүү дээ” гэж хэлэв.

Тэгээд цааш явж байтал урдаас нь цагаан галуу хөвсөөр ирэв.

Шанаган хорхойнууд бас л: “Ээж ээ, ээж ээ” хэмээн тосон очив.

Тэгсэн цагаан галуу:

“Та нарын ээж ногоон өнгөтэй, бас вааг вааг гэж дуугардаг шүү дээ” гэв.

Шанаган хорхойнууд тийм амьтан хайж цааш хөвлөө.

Гэтэл мэлхий ээж гэнэтхэн үсэрч ирээд:

“Хүүхдүүд ээ, ээж нь ирлээ” гэв. Шанаган хорхойнууд ихэд гайхав.

“Та яагаад биднээс өөр байгаа юм бэ?” гэж асуужээ.

Мэлхий ээж:

“Та нар өсөж том болоод надтай адилхан болно” гэж хэллээ.


Мэлхий ээж үнэн хэлсэн болов уу?

Замаг- усны дотор ургадаг ургамлын нэр, гол төлөв ногоон өнгөтэй байдаг.


Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Ахлах
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа 2. Байгаль, нийгмийн орчин 3. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	Танин мэдэхүйн түвшин: 1. Сэргээн санах 2. Задлан шинжлэх 3. Ойлгох
Илрүүлэх чадвар: 1. Уншиж, ярьж өгсөн үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, өөрийнхөөрөө давтан ярих 2. Орчны ургамал, гэрийн тэжээмэл амьтдыг онцлог шинжээр нь таньж ялгах, тайлбарлах 3. Дэс тоог хэрэглэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Үлгэр яриарай.	
Хэрэглэгдэхүүн	“Шанаган хорхой ээжийгээ эрсэн нь” үлгэрийн үйл явдлыг харуулсан зурагт үзүүлэн болон PDF файлаас сонгож ашиглах, нугас, загас, яст мэлхий, цагаан галуу, мэлхийн зурагт карт, Мэлхийн үүсэл хөгжлийг харуулсан 4 ширхэг зурагт үзүүлэн	
Даалгаврын заавар	Үлгэрийг сонсоод, асуултын дагуу үйл явдлыг ярина. Амьтдыг шанаган хорхойтой тааралдсан дарааллаар нэрлэж, дэс тоогоор хэлнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	1. Үлгэрийн үйл явдлыг харуулсан зурагт үзүүлэн ашиглан ярина. 2. Одоо үлгэрийн үйл явдлыг бодож байгаад асуултад хариулаарай. a. Үлгэрт ямар ямар дүр гарсан бэ? (шанаган хорхой, нугас, загас, яст мэлхий, цагаан галуу, мэлхий) b. Шанаган хорхойнуудын ээж ямар дүр төрхтэй вэ? c. “Танай ээж дөрвөн хөлтэй шүү дээ” гэж ямар амьтан хэлсэн бэ? (загас) d. Шанаган хорхойнууд ээжтэйгээ уулзсан хэсгийг багшдаа яриад өгөөрэй 3. Үлгэрт “Вааг вааг дуугардаг” гэж ямар амьтныг хэлж байна вэ? a. Мэлхийн үүсэл харуулсан зургийг ажиглаад дараалалд оруулж байрлуулаарай. b. Яаж мэлхий бий болдог талаар ярьж өгөөрэй. 4. Шанаган хорхойтой тааралдсан амьтдыг дарааллаар нь хэлээрэй. / тавдугаарт мэлхийтэй тааралдсан гэдгийг багш жишээ болгож хэлнэ/	1. “Шанаган хорхой ээжийгээ эрсэн нь” үлгэрийн зурагт үзүүлэн (PDF файл ашиглаж болно) харуулна. Даалгавар №1.1 дугаартай үзүүлэнг ашиглана. 3. Мэлхийн үүсэл хөгжлийг харуулсан 4 ширхэг зурагт үзүүлэнг ширээн дээр тавина. Даалгавар №1.2 дугаартай үзүүлэнг ашиглана. 4. Үлгэрт гардаг амьтдын зурагт картын дарааллыг нь өөрчилж хүүхдэд өгнө. Даалгавар №1.3 дугаартай үзүүлэнг ашиглана.
Дэмжлэг	Даалгавар гүйцэтгэхийн өмнө тавдугаарт мэлхийтэй тааралдсан гэдгийг хэлж өгнө.	
Анхаарах зүйл	Зөв хариулт авахын тулд дөхүүлэх асуулт тавьж болохгүй.	


Ахлах бүлэг: Хэл яриа, Байгаль, нийгмийн орчин, Математикийн энгийн төсөөлөл
“Үлгэр яриарай.” Даалгавар №1.2 (1 хувь хэвлэнэ.)



Даалгавар №1.2 (1 хувь хэвлэнэ.)



Ахлах бүлэг: Хэл яриа, Байгаль, нийгмийн орчин, Математикийн энгийн төсөөлөл
“Үлгэр яриарай.” Даалгавар №1.3 (1 хувь хэвлэнэ.)




Даалгаврын дугаар: 2	Бүлэг: Ахлах
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Дүрслэх урлаг 2. Математикийн энгийн төсөөлөл 3. Нийгэмшихүй
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	Танин мэдэхүйн түвшин: 1. Бүтээх 2. Үнэлэх 3. Хэрэглэх
Илрүүлэх чадвар: 1. Цаасаар эд зүйлс, амьтан ургамал дүрслэх 2. Энгийн хэрэгсэл ашиглан хэмжилт хийх 3. 2-3 шатлалтай зааврыг ойлгож биелүүлэх, хэрэглэгдэхүүнээ хураах	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай


Даалгавар	Мэлхий бүтээгээрэй.	
Хэрэглэгдэхүүн	өнгийн цаас 1 багц, эсгий бал, хүүхдийн тоогоор өнгийн цаасаар хайчилж бэлтгэсэн тууз цааснууд, мэлхий эвхэх дараалал харуулсан зурагт аргачлал ширээ бүрд 1-2 ширхэг, жижиг дөрвөлжин дүрс 1-2 ширхэг, скоч	
Даалгаврын заавар	Цаасаар мэлхий хийнэ. Хүүхэд мэлхийн үсэрч буусан цэгт дүрс нааж тэмдэглэнэ. Эхлэлээс үсэрч буусан зайг туузан цаасан дээр тэмдэглэн хэмжилт хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<p>Зурагт үзүүлсний дагуу хамтдаа цаасаар мэлхий хийцгээе. Багшийгаа дагаад хийгээрэй.</p> <p>Цаасаа сонгож аваарай. /ногоон/</p> <ol style="list-style-type: none"> 1. Өнгийн цаасаа голоор нь 1 нугалаарай. Ирмэгүүдээ сайн тэнцүүлнэ. 2. Нугалсан хэсгээ буцааж дэлгээд, нөгөө тал руу 2 ирмэгээ тэнцүүлж нугалаарай. 3. Цаасаа дахин дэлгээд, дороос дээш чиглэлтэй голын зураас хүртэл нугална. 4. Баруун дээд өнцгийг голын зураас хүртэл гурвалжилж нугалаарай. 5. Одоо зүүн дээд өнцгийг голын зураас хүртэл гурвалжилж нугална. 6. Сая нугалсан хэсгийнхээ баруун талыг нь голын зураас хүртэл нугалаарай. 7. Зүүн талыг нь мөн адил голын зураас хүртэл нугалаарай. 8. Доод хэсгээс нь бариад гурвалжин руу буюу дээшээ чиглэлтэй голын зураас хүртэл нугалаарай. 9. Сая нугалсан хэсгээ буцааж гадагш эргүүлэн доод ирмэгтэй тэнцүүлж нугалаарай. 10. Эсгий бал ашиглан нүд, амыг зурж дүрсэлнэ. <p>Цаасаар хийсэн мэлхийг үсэргэж тоглоё.</p>	<p>Эсгий бал бэлтгэж тавьсан байна.</p> <p>Багш зурагт аргачлалын дагуу мэлхий нугалж, хүүхдээр дагуулж хийлгэнэ. Зурагт аргачлалыг өгнө. Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</p> <p>Тууз цааснуудаас хүүхдээр сонголт хийлгээрэй. Даалгавар №2.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</p> <p>Багш цаасаар хийсэн мэлхийн нурууны ирмэг хэсэгт хуруугаар хүчтэй дарж үсэргэнэ.</p>

	<ol style="list-style-type: none"> 1. Би мэлхийг зураасны ард байрлуулаад үсэргэж үзүүлнэ. Мэлхий хаанаас хаана хүртэл үсрэхийг чи анхааралтай ажиглаарай. 2. Мэлхийн үсрээд буусан хэсэгт дөрвөлжин дүрс нааж тэмдэглээрэй. 3. Мэлхийн үсэрч буусан зайг тууз цаас ашиглан хэмжээд, тэр цаасан дээрээ зураас зурж тэмдэглээрэй. /2,3 дугаарт заасан үйлийг хүүхдээр 1 удаа хийлгэж, турших боломж олгоорой./ 	<p>Мэлхийн үсрээд буусан газрыг тэмдэглэж, хэмжилт хийхийг 1 удаа туршиж үзэхэд багш чиглүүлж өгнө.</p> <p>Хүүхэд 2-3 шатлалтай зааврыг багш хүүхдэд ойлгомжтой хэлж өгнө.</p>
Дэмжлэг	<ol style="list-style-type: none"> 1. Мэлхийг цаасаар нугалахдаа хүүхдийг дагуулан хийлгэнэ. 2. Мэлхийг үсэрсний дараа жижиг дөрвөлжин дүрс дээр скоч нааж хүүхдэд өгнө. 3. Мэлхийн үсрээд буусан газрыг тэмдэглэж, хэмжилт хийхийг ХҮҮХЭД 1 удаа туршиж үзнэ. Энэ үед багш чиглүүлж өгнө. 	
Анхаарах зүйл	<ol style="list-style-type: none"> 1. Мэлхий нугалах үйл ажиллагааг хийхдээ 1 ширээнд 4-өөс олон хүүхэд суулгахгүй. 2. Хүүхэд цаасыг нугалахад багш оролцохгүй. 3. Багш мэлхийг үсэргэхдээ өөрийн болон хүүхдийн нугалсан мэлхийн алийг нь ч ашиглаж болно. 4. Хэмжилт хийх туузан цаас богинодсон тохиолдолд цааснуудыг холбож уртасгаарай. 5. Мэлхийн үсрээд буусан газрыг тэмдэглэж, хэмжилт хийхийг ХҮҮХЭД 1 удаа туршиж үзэх нь оноожуулалтад орохгүй. 6. Хэмжилт хийхэд хэрэглэх жижиг дөрвөлжин дүрс нь ОЛОН ДАХИН АШИГЛАХ ТУЛ хатуу цаасаар хийгдсэн байвал сайн. 	


Ахлах бүлэг: Дүрслэх урлаг Математикийн энгийн төсөөлөл
Нийгэмшихүй -“ Мэлхий бүтээгээрэй.” Даалгавар №2.1 (ширээ тус бүрд 2 ширхэг)




1. Өнгийн цаасаа голоор нь 1 нугалаарай.
2. Нугалсан хэсгээ буцааж дэлгээд, нөгөө тал руу 2 ирмэгээ тэнцүүлж нугалаарай.




3. Цаасаа дахин дэлгээд, дороос дээш чиглэлтэй голын зураас хүртэл нугална.




4. 5. Баруун дээд өнцгийг голын зураас хүртэл гурвалжилж нугалаарай. зүүн дээд өнцгийг голын зураас хүртэл гурвалжилж нугална.




- 6.7. Баруун, зүүн талыг нь голын зураас хүртэл нугална.



8. Доод хэсгээс нь бариад гурвалжин руу буюу дээшээ чиглэлтэй голын зураас хүртэл нугалаарай.



9. Нугалсан хэсгээ буцааж гадагш эргүүлэн доод ирмэгтэй тэнцүүлж нугална.




10. Цаасаа нөгөө талаар нь эргүүлж тавина. Нүд, амыг зурна.



МЭЛХИЙ БЭЛЭН БОЛЛОО.

Ахлах бүлэг: Дүрслэх урлаг Математикийн энгийн төсөөлөл





Нийгэмшихүй -“Мэлхий бүтээгээрэй.” Даалгавар №2.2 (хэмжилт хийхэд хүрэлцээтэй байх, хүүхэд бүрд 2-3 ширхэг тууз цаас)




Даалгаврын дугаар: 3	Бүлэг: Ахлах
Хөгжлийн чиглэл: Бие бялдар, Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Эрүүл мэнд 2. Хэл яриа
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	Танин мэдэхүйн түвшин: 1. Хэрэглэх 2. Задлан шинжлэх
Илрүүлэх чадвар: 1. Гэмтэхээс болгоомжлох 2. Үгийн утгыг ойлгох, өдөр тутам хэрэглэгддэг үгсийг яриандаа хэрэглэж ярих	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай





Даалгавар	Болгоомжтой байгаарай.	
Хэрэглэгдэхүүн	Газар хөдлөх үед цонхны хажууд зогсож байгаа хүүхэд, ширээн доор ороод ширээний хөлнөөс барьсан хүүхэд, хурдан гүйж байгаа хүүхдүүд, чанга хашгирч байгаа хүүхдүүдийн зурагт үзүүлэн, өнгийн харандаа	
Даалгаврын заавар	Газар хөдлөх үед ямар үйлдэл хийх нь зөв эсвэл бурууг ялгаж, баруун талд байгаа дөрвөлжин дүрс дотор болно гэвэл ногоон +, болохгүй гэвэл цэнхэр өнгөөр x тэмдэглэгээг хийнэ. Зурж тэмдэглэснээ тайлбарлаж ярина.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	
	<p>Зургийг ажиглаарай.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүүхдүүд юу хийж байгааг хэлээрэй. 2. Газар хөдлөх үед ямар үйлдэл хийж болох вэ? Болно гэвэл баруун талд байгаа дөрвөлжин дүрс дотор ногоон өнгөөр +, болохгүй гэвэл цэнхэр өнгөөр x тэмдэглэгээрэй. 3. Зурж тэмдэглэснээ тайлбарлаарай. <ol style="list-style-type: none"> a. Цонхны дэргэд зогсох нь зөв үү? Яагаад? b. Ширээн доор орж, хөлнөөс нь сайн бариад суух зөв үү? Яагаад? c. Яарч сандран, гүйж болох уу? Яагаад? d. Чанга хашгирч тусламж хүсэх хэрэгтэй юу? Яагаад? 	<p style="text-align: center;">Багшийн хийх үйлдэл</p> <p>Зурагт үзүүлэн, өнгийн харандааг бэлтгэж тавьсан байна. Даалгавар №3.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</p>

Ахлах бүлэг: Эрүүл мэнд, Хэл яриа -“ Болгоомжтой байгаарай.” Даалгавар №3.1
(хүүхдийн тоогоор)

 <input data-bbox="726 481 805 560" type="checkbox"/>	 <input data-bbox="1268 481 1348 560" type="checkbox"/>
 <input data-bbox="742 795 821 873" type="checkbox"/>	 <input data-bbox="1268 795 1348 873" type="checkbox"/>

+ X



 <input data-bbox="742 1417 821 1496" type="checkbox"/>	 <input data-bbox="1284 1417 1364 1496" type="checkbox"/>
 <input data-bbox="742 1731 821 1809" type="checkbox"/>	 <input data-bbox="1284 1731 1364 1809" type="checkbox"/>

+ X